



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.26 № 1/543  
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН  
СҮМҮН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА Г.БОЛДОО  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Тариалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Тариалан Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Тариалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг,

нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (5 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Тариалан сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Тариалан сумын Сонгуулийн хороонд

Хавсралт 5. хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



## 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ТАРИАЛАН СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтолцоог, үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд сууринласан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Тариалан сумын хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш хариуцлагатай Тариалан суммаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож

- Иргэдийнхээ эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал
- Үндэстэн ястныхаа өв уламжлал, орон нутгийнхаа түүх соёлоо дээдэлсэн байна

ТАРИАЛАН СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2024-2028 оны Орон нутгийн сонгуульд оролцох “ӨӨР БОДЛОГО ӨӨР ИРЭЭДҮЙ” мөрийн хөтөлбөрөө олон түмнээ толилуулж байна.

### НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 1.1 Эрэлттэй боловсрол, баталгаатай ажлын байр
- 1.2 Эрүүл мэндийн хүртээмжтэй үйлчилгээ
- 1.3 Хүн амын хөгжил

- Хүн амын өсөлт, өрх гэр бүл
- Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн хамгаалал.

- 1.4 Соёл, урлаг, Спорт

### ХОЁР. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛД ТҮШИГЛЭСЭН ӨСӨЛТИЙН БОДЛОГО

- Жижиг, дунд бизнес
- Өрхийн үйлдвэрлэл
- Малчин өрхийг дэмжих Чинээлэг малчин хөтөлбөр

### ГУРАВ. ИРГЭДЭЭ ДЭЭДЭЛСЭН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

### НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 1.1 Суралцагсадад ээлтэй боловсрол
- Өөрчлөгдөн буй хөдөлмөрийн зах зээл, шинэ төрлийн ажлын байрны шаардлагыг хангах хөрвөх чадвар өндөр мэдлэг бүхий мэргэжилтэй мэргэшсэн хүний нөөц бүрдүүлэх.

0000000001



- Хүүхэд бүрийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж төрөлх нутгийнхаа соёл уламжлал, түүхээр бахархдаг хүмүүжил олгох “Бахархалт Монгол хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Цэцэрлэг сургуулийн анги дүүргэлтийг 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.
- Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ иргэдтэй ажиллах мэргэжилтэн, сэтгэл судлаач багш нарыг захиалгаар сургаж бэлтгэн сургуулийн насны хүүхдийн сургалтад хамруулах төлөвлөгөөт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Эцэг эх асран хамгаалагчид багш суралцагсдын Гурвалсан холбоог үүсгэн хүүхэд үүргээ эрхэмлэн эрхээ эдлэх боломжийг судалж хэрэгжүүлнэ.
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заал, барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандарт шаардлагыг мөрдүүлэхэд онцгой анхаарч тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам шатыг барилга бүхэнд суурилуулна.
- Өсвөр үе залуучуудад англи, орос хэл болон З дахь орны хэл сургах санаачилга хөтөлбөр төслийг дэмжиж ажиллана.
- Бүх нийтийн цахим боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сайтар хангаж хамрагдах хувийг нэмэгдүүлнэ.

### **1.2. Эрүүл мэндийн хүртээмжтэй үйлчилгээ**

- Амь эрсдүүлэх өвчнөөр өвчилж буй шалтгаан нөхцөлийг нарийвчлан судалж, нас барагтыг бууруулах, эрт илрүүлэлт оношилгоо, эмчилгээний чанарыг дээшлүүлэн улсын дундаж түвшинд хүргэнэ.
- Иргэн бүрийг насны бүлэгт тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.
- ЭМ-ийн даатгал голлосон урьдчилан сэргийлэх болон эмчилгээний тусlamж үйлчилгээний хүрээг өргөтгөх бөгөөд ЭМ-ийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.
- Уламжлалт анагаах ухааны чиглэлээр ажиллаж буй хувийн эмнэлгүүдийг дэмжиж ажиллана.
- Хүн амын ундны усны эрүүл ахуй болон ус түгээгүүрийн газруудын стандартын баримтлан Эрүүл ус хөтөлбөрийг санаачлан ажиллана.

### **1.3 Хүн Амын Хөгжил**

#### **\* Хүн амын хөгжил, өрх гэр бүл**

- Хүүхдийн хүмүүжил төлөвшилд онцгой анхаарч цэцэрлэгийн ёмнох насны хүүхдийг гэр бүлийнхээ орчинд өсөж хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, заах аргын анхан шатны мэдлэг олгоно.
- Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт зөвлөмжөөр хангах ажлыг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулна.

0000000062

1720000061 2070605

- Тариалан суманд анхны орон сууцны хорооллын дахин төлөвлөлтийг эхлүүлж ипотекийн зээлд хамруулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж , дарамт мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулна.
- Хүүхдэд ээлтэй орчныг шат дараалан бий болгоно
- „Гэр бүлийн өдөр”-ийг уламжлал болгон тэмдэглэж байх, гэр бүл нөхөн үржихүйн боловсрол олгох ажлыг чанаржуулна .
- Ахмад настны асрамж халамжийг дэмжин ажиллана

**\* Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

- Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлтийн судалгааны чанарыг сайжруулна.
- Хэрэгцээт ажил мэргэжлийг эдийн засгийн салбар, төсвийн байгууллага бүрээр нарийвчлан гаргаж, их дээд сургууль мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.
- Халамж шаардлагатай өрх иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлнэ.
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл хэлбэрийг нэмэгдүүлнэ.
- Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажлыг дэмжиж урамшуулна.

**1.4 Соёл, урлаг, спорт**

- Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжинэ.
- Соёлын өвийн бүтээгдэхүүн үйлчилгээ, ардын авьяастныг улс болоод олон улсын шоу урлагийн зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- Мэргэжлийн урлагийн сургалтын байгууллага төгсөгч сумын харьят иргэдэд эзэмшсэн ур чадвараа хөгжүүлэх, уран бүтээлээ олны хүртээл болгоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Спортын болон бялдаржуулах, эрүүлжүүлэх төвүүд, чөлөөт цагийн үйлчилгээг үзүүлэх бүжгийн заалнуудын үйл ажиллагааг тогтмолжуулж хамтран ажиллана.
- Тариалан суманд жилдээ 1-ээс доошгүй удаа спортын төрлүүдийн улс аймаг сумын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах талаар холбогдох газруудтай хамтран ажиллана.
- Спорт клуб, тамирчдыг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.
- Гүйлтийн болон дугуйн зам байгуулах ажлын зураг төсвийг хийлгэн бариулах хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлнэ.

**ХОЁР. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛД СУУРИЛСАН ӨСӨЛТИЙН БОДЛОГО**

0000000063

172009001-0070605


### \* Жижиг дунд бизнес

- Бизнест учирдаг шат шатны дарамтыг арилгах чиглэлд эрчимтэй ажиллана.
- Өмчийн эрхийг баталгаажуулж, хувийн өмчийг хамгаалах чиглэлд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.
- Гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг бүх талаар нь дэмжинэ.
- Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал дарамтыг арилгаж татвар төлөгч ААН-үүддээ үйлчилдэг, зөвлөдөг байх нөхцөл боломжийг бий болгоно.
- Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөө аж ахуй, хөнгөн жижиг дунд үйлдвэр, цех байгуулах, үйлдвэрлэлээ өсгөж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- ЖДҮ-үүдэд олгох зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Барилгын материалын үйлдвэрлэлийг тусгайлан дэмжинэ.
- Max, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг орон нутгийн үндэсний үйлдвэрлэлээр бүрэн хангаж эрүүл аюулгүй байдлын баталгааг дээшлүүлнэ.
- Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал тавих хяналтыг сайжруулна.
- Иргэдийн хүнсний хэрэглээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуйг эрхлэх санаачилгыг бүх талаар нь дэмжинэ.
- Орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн байгууллагууд хэрэглэдэг байх журам тогтоож мөрдөнө.
- Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг орон нутагтаа сонгон шалгаруулдаг, түүнд зөвхөн орон нутгийн хөрөнгө оруулагч ААН-үүдийг оролцуулах чиглэл барьж ажиллана.
- Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.
- Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжин сумын хүн амыг шинэ ургацын ногоогоор хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Жимс, жимсгэнийн орон нутгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- Малчин өрхийн бизнесийг дэмжин Чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлж малыг эдийн засгийн эргэлтэд оруулж эрсдэлээс урьдчилан сэргийлнэ

### \* Дэд бүтэц

- Тариалан НАУТ ХХК хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэмэлт дулааны эх үүсвэр бий болгохыг зорьж ажиллана.
- Суурин газрын ерөнхий төлөвлөгөөг дахин хийлгэж сумын эдэлбэр газар, суурьшлын бүсийн газар нутгийг өргөтгөх чиглэлд идэвхтэй ажиллана. Хог хаягдлыг зөөх, ангилах, дахин боловсруулах чиглэлд дэвшил гаргаж ажиллана.

0000000064




1720000001-21-070605

- Шахмал түлш үйлдвэрлэлийг дэмжиж сурталчлан гэр хорооллын оршин суугчдын түлшний хэрэглээнд нэвтрүүлэх, агаарын бохирдлыг бууруулах талаар төлөвлөгөө гарган ажиллана.
- Иргэд, олон нийтийн амьдралд сайнаар нелөөлөх жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх, аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- Гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн дэд бүтцэд холбож, салаалалтын төвлөрсөн эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- Шивэрт ,Улаанчулуутын голын эрэг дагасан ногоон бүс, орчин үеийн дизайн шийдэлтэй гүүрэн гарц, нөгөө талын эргийг иргэдийн амралт зугаалгын цэцэрлэгт хүрээлэн болгон тохижуулах зэрэг байгууламжийн зураг төсөл боловсруулна.

#### **ГУРАВ. ИРГЭДЭЭ ДЭЭДЭЛСЭН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

- Сум багийн удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайлангаа иргэдэд нээлттэй тайлагнадаг ил тод нээлттэй байдлыг бүрдүүлнэ.
- Сонгогдсон, томилогдсон төрийн албан тушаалтан нь ёс зүйн зөрчил гаргасан бол сонгогчдоосоо учлал гүйдаг ажлын хариуцлагын журмыг бий болгоно.
- Авлига, албан тушаалын гэмт хэрэг болон Засгийн газрын 5 Ш ажиллагааг дэмжин ажиллана .
- Хууль сурталчлах, таниулах ажлыг тогтмол хийж олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай үр дүнтэй хүргэнэ.
- Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, сонирхлын зөрчлөөс ангид олон нийтэд ил тод болгон зохион байгуулна.
- Газар ашиглалт, хот суурин газрын төлөвлөлт, байгалийн нөөц ашиглах замаар эдийн засгийн өсөлтийг хангах бодлогыг төлөвлөж хэрэгжүүлнэ.
- Ногоон орчин буй болгож тохижуулсан иргэд, ААН-ийг урамшуулна.
- Иргэдэд түргэн, соёлтой үйлчлэх, мэдээллээр хангах, өргөдөл гомдол, хүсэлтэд шуурхай хариу өгөх зорилго бүхий утгах үйлчилгээ, шуурхай утас ажиллуулж, түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.
- Хөрш болон гадаад орнуудын хот дүүрэг, мужуудтай тогтоосон найрамдалт харилцааг үргэлжлүүлнэ.

**ТАРИАЛАН СУМЫН АРДЧИЛСАН НАМ**



0000000065